

Хэрэггүй зүйл гэж үгүй



Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



“Бурханлаг өөрийгөө эргэн олох”-ын тулд номын мөрд хичээн шамдах

Саяхан нэг хүн надаас “Бурханы хутгийг олохын тулд юуг хэрхэн хийвэл зохилтой вэ?” хэмээн асуусан юм. Бурханы сургаалыг “Бурханы хутаг олох сургаал” хэмээн тайлбарлах явдал байдаг тул тэгэхийн тулд яах ёстой вэ гэсэн асуулт байсан юм.

Гэвч “Цагаан Лянхуа Судар”-ын “Түүнчлэн Ирсэний насны хэмжээг өгүүлэх бүлэг”-ийг сайтар ухаж ойлговоос бид заавал бурханы хутгийг олохын төлөө номын мөрд хичээн шамдах учиргүй мэт. Тэгээд би өөрийн ойлголтын хүрээнд ингэж хариулсан юм.

“Бурханы хутгийг олох гэдэг нь “жинхэнэ өөрийгөө гэгээрэх”-ийг хэлж байж ч болно. Тэр утгаар нь авч үзэх юм бол бид хэдийн гэгээрсэн гэж сургасан байдаг. Тиймээс бурханы хутгийг олохын тулд номын мөрд шамддаг гэхээсээ илүү жинхэнэ өөрийгөө гэгээрсний дараах зам мөрийг хэрэгжүүлж байгаа ба тэр нь бидний өдөр тутмын амьдрал гэж хэлж болно. Тэгвэл гэгээрчихсэн мөртлөө яагаад номын мөрд үргэлжлүүлэн шамдар ёстой вэ гэвэл бид заримдаа өөрсдийн үндсэн мөн чанарыг мартчихдаг учраас тэр билээ. Гэгээрсэн “Жинхэнэ өөрийгөө” эргэж олохын тулд номын мөрд хичээн шамддаг ба тэр нь өөрөө сүсэг бишрэл бүхий амьдрал юм.

Янз бүрийн сэтгэл зовоосон асуудал, бэрхшээл зовлонтой учирч байдаг хорвоо хэдий ч бид хэдийн жинхэнэ өөрийгөө олчихсон тул тэрхүү өөртөө болон мөн бусдад (бусад = би) итгэж, хамтдаа номын мөрд хичээн зүтгэснээр энэ хорвоо ертөнц тэр хэвээрээ “Амар амгалан ертөнц” болж хувирдаг хэмээн сургасан байгаа юм. Бурханы ийм сургаалтай учирч, амь насны нандин чухлыг ухаарснаар талархмаар өдөр хоногийг өнгөрүүлж чадна. Гэвч харамсалтай нь бид заримдаа тийм аз жаргалтай өөрийгөө мартчихдаг учраас зовж шаналдаг билээ.



Өөрийн асуудал гэж бодох

“Түүнчлэн Ирсэний насны хэмжээг өгүүлэх бүлэг”-т “Бурханы сургаал бол бүх хүмүүсийг төөрөгдлийн ертөнцөөс аврах сургаал юм.” гэсэн байдаг.

Хүмүүсийг зовлонгоос гэтэлгэх, төөрөгдлийн ертөнцөөс аврах гээд бо- дохоор төсөөлөхөд бэрх санагдаж магадгүй. Гэхдээ энэ нь өөрөөр хэлбэл үргэлж зүрх сэтгэлээсээ ямар аз жаргалтай юм бэ, ямар гоё юм бэ, сайхан юм бэ гэж хэлж чаддаг хүн болно гэсэн үг юм. Хамгийн гол нь өөрийн мөн чанараа мартажгүй байвал тэрхүү аз жаргалыг бодитоор мэдэрч чадна.

Бурхан янз бүрийн хэлбэрээр, эсвэл ямар нэг зүйлээр дамжуулж биднийг төөрөгдлийн ертөнцөөс гарах дохиог өгч байдаг. Хязгааргүй уран аргас гэж сударт гардагчлан гэгээнтэн хийгээд суут хүмүүсийн сургаал төдийгүй сайн, мууг агуулсан энэ хорвоо ертөнцийн бүхий л явдал нь “Жинхэнэ өөрийгөө” эргэн олж авах, аз жаргалыг амтлахад туслах дохио, нөхцөл боломж болдог гэсэн үг.

Зарим хүн гэмтэл бэртэл болон өвчин зовлонгоор дамжуулж жинхэнэ өөрийгөө анзаарч болох ба зарим нь бусдын өвчин зовлонг ойлгодог болсноор энэрэнгүй нигүүлсэнгүй сэтгэл нь эргэн сэргэж ч болно. Мөн бусдын аз жаргалыг хараад өөрт нь тохиолдсон мэт баярлаж, баярын нулимс унагаж байвал тэр нь бурханлаг чанар нь сэргэн ил гарч ирсэн байна гэсэн үг юм.

Бурхан бүх хүнийг аврахын төлөө, аз жаргалтай болоосой хэмээн хүсдэг. Бид бусдын гуниг, баяр хөөрийг өөрийн асуудал гэж хүлээж авдаг болох юм бол тэрхүү бурханы хүсэл таны сэтгэл зүрхэнд үндэслэсэн байна гэж ойлгож болно.

Шинэ төрлийн корона вирусын цар тахал зэрэг дэлхий нийтийг хамарсан үйл явдал хүн бүрт нэгийг бодогдуулж, хоёрыг тунгаахад хүргэж буй биз ээ. Бид үүнийг өөрийн асуудал хэмээн хүлээн авч, тэндээс суралцаж чадах аваас энэ хорвоо дэлхийд хэрэггүй зүйл гэж огтхон ч байхгүй гэсэн үг болно. Мөн тэр бүхэн “Жинхэнэ өөрийгөө” буюу бурханлаг өөрийгөө эргэн олж авах боломж болох болно.

Харь орны хүний асуудлыг өөрийн асуудал хэмээн хүлээн авч, дэлхийн хүмүүсийн аз жаргал, сайн сайхны төлөө залбирч буй хүмүүс бол бүгд хүсэл зорилго нэгт нөхөд буюу дэлхийн номын анд нөхөд юм.

Өөрийн болон өрөөл бусдын бурханлаг чанарт итгэгч бидний “итгэл үнэмшил”, өөрөөр хэлбэл сүсэг бишрэл нь дэлхийд жинхэнэ аз жаргалыг түгээх үндэс болно гэж бодож байна.

Жич: Бусад = Би

Бусад хүн хийгээд аливаа оршихуйг өөртэйгөө нэгэн бүхэл гэж харвал, өөрөөс бусад бүхэн “Өөртэй” нэгэн бүхэл “Бусад” гэж ойлгож болно.

«Косей» 2020 оны 8 дугаар сарын дугаар



Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

«Оройн Дээд Цагаан Лянхуа Судар»

Эрдэм буяныг ялган өгүүлэх 17 дугаар бүлэг
(Эхэн хагас)

Уг бүлэгт өмнөх “Түүнчлэн Ирсэний насны чинээг өгүүлэх 16 дугаар бүлэг”-г сургасан “Бурханы бие бол сансар огторгуйн түмэн зүйлийг амьдруулж буй Ялж Төгс Нөгчсөн Язгуурын Будда бөгөөд үргэлж бидэнтэй хамт өнө мөнхөд байдаг.” гэдгийг сайтар ойлгосон хүний олж эдлэх эрдэм буяныг 12 бүлэгт хуваан тайлбарлаж, сүсэг бишрэл бүхий зөв амьдрал ямар байх ёстойг нарийн тодорхой сургасан байдаг.

Амьдралын утга учрыг ойлгох их эрдэм буян

Тэрхүү 12 бүлгийн тухай нэг бүрчлэн тайлбарлахгүй ба нэгтгээд хэлбэл бид эхлэл төгсгөл үгүй, өнө мөнхөд оршигч Ялж Төгс Нөгчсөн Язгуурын Буддагийн ачаар амьдарч буй гэсэн сүсэг бишрэлийн суурийг ойлгож чадвал тэрхүү итгэл үнэмшлээ улам бүр гүнзгийрүүлэх, түүнийг бусдад түгээн дэлгэрүүлэх хүч чадвар хязгааргүй ихээр оргилон гарч ирнэ. Улмаар тэрхүү итгэл үнэмшилдээ тууштай байх аваас хэзээ нэгэн цагт бурхан мэт үнэмлэхүй гэгээрлийн ертөнцөд хүрэх гэсэн хамгийн агуу, дээд эрдэм буяныг хүртэл олж эдэлж чадна хэмээн батласан байна.

Мэдээж бурханы түвшинд жирийн нэг бурханы зам мөр хөөснөөр хүрэх боломжгүй. Энэхүү бүлэгт найман удаа төрөл арилжих хугацаанд бурханы зам мөрд шамдаж байж бурханы түвшинд хүрсэн бодисадва ч бий гэж айлдсан байдаг. Гэвч зөв сүсэг бишрэлтэйгээр хичээх л юм бол хэзээ нэгэн цагт Шагжамүни бурхантай адил болж чадна гэсэн жинхэнэ үнэн хүмүүс бидэнд хичнээн их итгэл найдварыг төрүүлж байна вэ. Энэ гэрэл гэгээ байхад л бүх хүний амьдрал жинхэнэ утга учиртай, болох болно.

Зөвхөн мөнгө олж эсвэл алдаж, хайрлаж дурлах юмуу бүтэлгүй хайртай учирч, удаан цаг хугацаа зарцуулж өндөр байр сууринд очлоо гэж бодтол жаахан алдаанаас болж түүнийгээ алдах... Ингэж хий хоосон баяр хөөр, уйтгар гуниг ээлжилсээр амьдралаа өнгөрүүлэх... Тухайн үедээ бол ямар ч л байсан сэтгэл



хангалуун байсан хэдий ч насан эцэслэх мөчид бүх л амьдралаа эргэн нэг харахад тэр бүгд “Аминч үзэл”-ээс болж, дэмий зүйлийн араас хөөцөлдөж, сэтгэлээ зовоож байснаас өөрцгүй байсныг ухаарч, тэр гэхийн аргагүй хий хоосон санагддаг.

Харин хэлбэрийн хувьд адилхан зовлон шаналал, баяр хөөр ээлжилсэн амьдралыг туулсан ч гэсэн “Сүсэг бишрэл” хэмээх бат бөх тулгуур багана байсан бол, унаж босонгоо ч болов бурханы түвшинд алхам алхамаар ойртож байна гэсэн “бат итгэл” байсан бол, хичнээн бэрх амьдрал байлаа ч сайхан амьдарч, сэтгэл өөдрөг дараа ертөнцөд очиж чадна. Бидний амь нас энэ ертөнцөөр хязгаарлагдаж төгсдөг юм биш. Дараах ертөнцөд ч мөн түүний дараагийн ертөнцөд ч гэсэн өдөр тутмын амьдралд баяр гуниг ээлжилсээр үүрд үргэлжилж, цаашлаад хүн болж төрөх нь байтугай там, бирдний ертөнцөд хүртэл дахин төрнө гэж бодохоор бодох төдийд л залхмаар санагдаж магадгүй.

Гэтэл жинхэнэ итгэл үнэмшилээ олж авсан хүн бол алхам алхамаар ч болов бурханы түвшинд хүрэхийн төлөө хичээсээр байх ухамсартай байдаг тул хичнээн урт аяллын зам байлаа ч түүнээс залхаж, нүүр буруулна гэж

үгүй. Үргэлж итгэл найдвараар дүүрэн, сэтгэл хангалуун амьдарч чадах болно. Үүнийг л зөвхөн жинхэнэ сүсэг бишрэлтэй хүний олж авч чадах ач буян гэж хэлэх ёстой болов уу.

Дээр нь жинхэнэ сүсэгтний хичээл зүтгэл гэдэг бол ганц өөрөө бурханы түвшинд хүрэхийг зорилгоо болгох бус аль болох олон хүнийг тэрхүү зам мөрдөө оруулахын төлөө давхар хичээж байдаг. Жинхэнэ сүсэгтэн нэмэгдэж л байвал тэр хирээр хүн төрөлхтөн тэр чигээрээ урагш ахин тэмүүлж, энэ ертөнц мөрөөдлийн амар амгалан ертөнцөд ойртох болно.

Судрын энэ хэсэгт айлдсан олон янзын эрдэм буяныг товчлон өгүүлбэл ийм байна.

Дүгнэлт хэсгээс суралцах эрмэлзлэлтэй байх

Уг бүлгийн сүүл хагасаас “Хотолд сайн бодисадвагийн зоригжуулсныг өгүүлэх 28 дугаар бүлэг” хүртэлхийг “Дүгнэлт хэсэг” гэх бөгөөд “Зөв итгэл үнэмшилтэй байснаар ямар үр дүн гарах вэ”, “Зөв итгэл үнэмшилтэй болохын тулд хэрхэн анхаарах хэрэгтэй вэ” гэдгийг голлон сургасан. Шагжмүни бурхан “Тэрхүү зөв итгэл үнэмшлийг хожмын ертөнцөд ч түгээн дэлгэрүүлээрэй.” хэмээн бүх шавь нартаа сургасан.

Дүгнэлт хэсгээс суралцахын ач буян

Уг “Эрдэм буяныг ялган өгүүлэх 17 дугаар бүлэг”-т сургасан ач буян бол сүсэг бишрэлийн ач буян юм. Сэтгэл зүрхнээсээ олж авах ач буян гэсэн үг. Дараах “Даган баясахуйн эрдэм буяныг өгүүлэх 18 дугаар бүлэг”-ийн эхэн хагас ч мөн адил агуулгатай. Харин сүүл хагаст нь бидний биед болон өдөр тутмын амьдралд гарч ирдэг ач буяны тухай сургасан.

Хүнээсээ хамаараад “Тийм ач буяны тухай сонсох шаардлагагүй. Цагаан Лянхуа Судрын гол утга санаа болсон “Нэг бүтэн хоёр хагас бүлэг”-ийг байнга суралцаж, түүний сургаалыг сэтгэлийнхээ угаас ойлгон ухамсарлаж, бурханы мөнх нас хийгээд бид ч мөн адил угаас Язгуурын Буддатай нэгэн бүхэл болохыг үнэн зүрхнээсээ ойлговол болох нь тэр.” гэж бодох хүн ч бий байх. Үнэхээр тэгж чадвал гайхалтай төгс сүсэг бишрэл болно. Гэвч тийм хүн арван мянгад нэг эсвэл зуун мянгад нэг байна уу үгүй юу... бодит байдал дээр бол туйлын бэрх асуудал.

Эгэл хүний гаслан нь зөвхөн мөрөөдлийн ертөнцийн талаар айлдах юм бол нэг л өөрөөс

нь хол хөндий, алс холын ертөнц мэтээр боддог. Тийм болохоор өөрт ойр асуудлаар, өдөр тутмын амьдралд нь нийцүүлэн тайлбарлах юм бол сургаал амьд мэт мэдрэгдэх болно. Дүгнэлт хэсгийн нэн тэргүүний гол ач холбогдол үүнд оршдог.

Мөн эгэл хүний сэтгэл бол нэн тогтворгүй байдаг. Сургаалын талархууштай талыг сайн мэдсэн ч зөвхөн толгойдоо л “Талархмаар сургаал байна даа.” гэж бодсон төдийгөөр хэзээ нэгэн цагт залхаж, шантарч болох талтай. Харин “Зөв сүсэг бишрэлийн дагуу хэрэгжүүлбээс бодитойгоор ингэж ахиж дэвшинэ.” хэмээн сургасан судрыг байнга уншаад байвал тогтож өгөхгүй байгаа сүсэг бишрэлийн сэтгэлээ тухай бүрт нь аргамжаад байх болно. Энэ бол дүгнэлт хэсгийн ээлжит чухал ач холбогдол болно.

Мөн бурхан зөвхөн бидэн шиг эгэл хүнд зориулан “Энэ сургаалыг түгээн дэлгэрүүлээрэй.” хэмээн хүссэн. Үнэхээр талархууштай хэрэг. Тэр үгийг сонсоод, тэр сэтгэлийг нь бодох тоолонд үгээр илэрхийлэхийн аргагүй урам зоригийг мэдрэх ба мөн зүрх зориг ч бадардаг. Энэ бол гурав дахь чухал ач холбогдол юм.

Юутай ч зуун мянган хүн дотор ерэн есөн мянга есөн зуун ерөн ес нь байдаг эгэл хүний хувьд “Дүгнэлт хэсэг” бол байхгүй байхын аргагүй чухал хэсэг учраас төлөв даруу сэтгэлээр “Тол хэсэг”-ийг сурсан шигээ шамдан суралцах хэрэгтэй.



Хэрэггүй зүйл гэж үгүй

Корона вирусээс үүдэн гэрээсээ гарахгүй байх нь хэдийн жирийн үзэгдэл болжээ. Харин та бүхэн маань сайн сууцгааж байна уу?

Нивано ерөнхийлөгч энэ сарын айлдвартаа коронаг оруулаад “Хэрэггүй зүйл гэж үгүй” хэмээн сургасан. Мөн бидний өдөр тутамдаа хэрэгжүүлдэг бурханы зам мөр нь бурхан болохын төлөө бус, гэгээрсэн жинхэнэ өөрийгөө эргэн олж авахын төлөөх үйл юм хэмээн онцолсон байна.

Амьдралд янз бүрийн зовлон бэрхшээл тулгардаг хэдий ч, тэр нь жинхэнэ өөрийгөө эргэн олж авах сэжүүр, нөхцөл болдог хэмээн айлджээ.


Бүхий л зүйлийг өөрийн асуудал гэж хүлээн авч, аливаа зүйлээс суралцъя гэсэн сэтгэлээр хандаж, үргэлж аз жаргалтай байна, ямар гоё юм бэ, ямар сайхан юм бэ гэж хэлж чаддаг хүн болохын төлөө хичээе гэж бодож байна.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Коичи





Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, USA
TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
POBox 33636, CA 90033, USA
TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
POBox 778, Pacifica, CA 94044, USA
TEL: 1-650-359-6951 Email: info@rksf.org
URL: <http://www.rksf.org>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
TEL: 1-212-867-5677 Email: rkny39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
TEL: 1-773-842-5654
Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA
TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-262-4437
Email: info@rkina.org URL: <http://www.rkina.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
(Mail) POBox 692042, San Antonio, TX 78269, USA
TEL: 1-210-561-7991 FAX: 1-210-696-7745
Email: dharmasanantonio@gmail.com
URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
TEL: 1-253-945-0024 FAX: 1-253-945-0261
Email: rkseattlewashington@gmail.com
URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

Facebook: <https://www.facebook.com/rishokosseikaidobrasil>
Instagram: <https://www.instagram.com/rkkbrasil>

Risho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

在家佛教韓國立正佼成會

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人在家佛教立正佼成會

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會

台灣台南市崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Risho Kosei-kai South Asia Division

Thai Risho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218

Risho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Risho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Risho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059, West Bengal, India

Risho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,
Bihar, India

Risho Kosei-kai of Patna Dharma Center

Risho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Risho Kosei-kai of Singapore

Risho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Risho Kosei-kai International of South Asia

Thai Risho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Risho Kosei-kai of Bangkok

Thai Risho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairisho@gmail.com

Risho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Risho Kosei-kai of Polonnaruwa

Risho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL/FAX: 880-31-626575

Risho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Risho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Risho Kosei-kai Patiya

China Clinic, Patiya Sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Risho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Risho Kosei-kai Chendhirpuni,

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Risho Kosei-kai Dhaka

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Risho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Risho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Risho Kosei-kai Cox's Bazar, Ramu Shibu

Risho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Buddiyskiy khram "Lotos"

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Risho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Risho Kosei-kai Friends in Shanghai

Risho Kosei-kai of Ulaanbaatar

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia

(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia

TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Risho Kosei-kai of Erdenet

Risho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia

TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Risho Kosei-kai of the UK

Risho Kosei-kai of Paris

Risho Kosei-kai of Venezia

Risho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibrk.org>